

## Оршин суугчийн үнэмлэх (RESIDENCE CARD) шалгуулах хүсэлт

Манай банкаар үйлчлүүлж буйд бид бүхэн маш их талархаж байна.

Тус банк нь Япон улсад оршин суудаг гадаад улсын харьяат үйлчлүүлэгчдийн “Оршин суугчийн үнэмлэх”-ийг шалган, оршин суух хугацаа хэтэрсэн эсэх, мөн хугацаа нь дуусах дөхөж байгаа эсэх зэргийг нягтлан үзэхээр болсон.

Танд төвөг болж буйд уучлал хүсэхийн ялдамд, доорх хугацааны дотор энэхүү захидлын хамтаар одоогийн хүчин төгөлдөр оршин суугчийн үнэмлэх (эх хувь) болон бэлэн мөнгөний карт эсвэл дансны дэвтэр болон бүртгэлтэй хувийн тамгыг биедээ аван өөрийн ойр байрлах Точиги банкны салбарын харилцах цонхонд хүрэлцэн ирэхийг хүсэж байна.

Доорх хугацааны дотор шалгуулаагүй тохиолдолд данс ашиглах боломжгүй болох ч тохиолдол гарч болзошгүй тул анхаарна уу.

Түүнчлэн, энэхүү явдлын талаар ямар нэг асуух асуулт байвал харилцах салбарт хандана уу.

Банкны салбарт ирэхдээ авч ирэх зүйлс

- Оршин суугчийн үнэмлэх
- Энэхүү захидал
- Бэлэн мөнгөний карт эсвэл дансны дэвтэр
- Бүртгэлтэй хувийн тамга

<Энэ захидлын тухай асуулт байвал>

Өөрт ойрхон банкны салбарт хандана уу.

(Хүлээн авах цагийн хуваарь: Ажлын өдөр 9 цаг - 17 цаг)

Жич: Бямба, ням, баярын өдрүүдэд болон 12/31-1/3 өдрүүд хамаарахгүй.